



“ТЭНГЭРЛЭГ ТУУЛЬС”-ЫН МОНГОЛ ОРЧУУЛГУУДЫГ
ХАЛТИ АЖИГЛАХУЙ ДОР ...

С.Эрдэнэмаам⁵⁵

Хураангуй: Алдаа эндэгдлээ хүлээн зөвшөөрч, түүнийгээ засаж залруулахын чухлыг сургамжилсан нэн гайхамшигтай мөнхийн сонгодог бүтээл болох “Тэнгэрлэг туульс”-ыг монгол уншигчдад толилуулсан хоёр монгол орчуулгаас цөөн хэдэн бадгийг тулган, зарим дүн шинжилгээ хийж, өөрийн үзэл бодлыг хуваалцах үүднээс энэхүү илтгэлийг бэлтгэлээ. Монгол яруу найргийн нэлээд түгээмэл бөгөөд хүртээмжтэй хэлбэр хэмээн судлаачдын үздэг туульсын зохиолтой Дантегийн эл найраглал агуулгын хувьд төсөөтэй учраас хоёр орчуулагчийн аль аль нь эл байдлыг нарийн тооцож, монгол ардын туульсын хэлбэрээр толгой холбон шүлэглэх цагаан шүлгийг орчуулгадаа тулгуур болгосон нь эх зохиолын агуулгыг бүрэн дүүрэн илэрхийлэн гаргахад дөхөм үзүүлсэн хэмээн үзэх үндэстэй байна. Бид энэхүү илтгэлдээ орчуулгуудыг бүхэлд нь шинжлэн үзэх, аль нэгийг нь шүүмжлэх, эсвэл дөвийлгөн магтах зорилго агуулаагүйг энэ даширамд дурдсуу.

Түлхүүр үг: там, ариуслын орон, диваажин, терцина, задгай цагаан шүлэг, итали эх, бүрэнхий ой

Италийн нэрт зохиолч Алигьери Данте (1265—1321)-гийн бараг найман зууны турш хүн төрөлхтний сэтгэл зүрхийг эзэмдсээр буй гандашгүй суут бүтээл болох “Тэнгэрлэг туульс” хэмээх яруу найргийн домогт энэхүү сор зохиолын хоёр дахь орчуулга уншигчдын гар дээр очоод жил шахам хугацаа өнгөрчээ. Анх удаа түүнийг манай авьяаслаг орчуулагч, утга зохиол судлаач Ц.Хасбаатар олон жил уйгагүй хөдөлмөрлөн, хүч авьяасаа дайчлан орчуулж, 1981, 1987, 1990 онуудад хэвлүүлэн монгол түмэндээ толилуулсан байдаг билээ. Харин хоёр дахь удаад “Монгол Улсын Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд, Соёлын гавьяат зүтгэлтэн, доктор, профессор, МЗЭ-ийн шагналт зохиолч, яруу найрагч, орчуулагч” Д.Цахилгаан орчуулжээ. Тэрээр энэхүү орчуулгынхаа талаарх товч танилцуулгад бичсэнээс үзэхэд: “... анхны монгол орчуулга 1981 онд хэвлэгджээ. Харамсалтай нь түүний орчуулга олон түмэнд хүрсэнгүй, уншигдсангүй. Утга зохиолд ойрхон, амьд сэрүүн олон хүнээс асуухад, “нэг хэвлэгдсэн байх аа” гэдгээс илүү юу ч хэлсэнгүй. Номыг нь олж унших гэтэл дэлгүүрээс олдсонгүй” [7:12] гэжээ. Эндээс үзэхэд, тэр бээр судалгаагаа жаахан дутуу хийжээ. Учир юун хэмээвээс, зөвхөн МУБИС-ийн номын санд гэхэд л Ц.Хасбаатарын орчуулсан “Тэнгэрлэг туульс. Там. УБ., 1981”, “Тэнгэрлэг туульс. Ариутгалын орчлон. УБ., 1987.”, “Тэнгэрлэг туульс. Диваажин. УБ., 1990.” хэмээх гурван орчуулга гурвуулаа цахим хэлбэрээрээ бүтнээрээ байж байна. Мөн “... олон түмэнд хүрсэнгүй, уншигдсангүй” хэмээх дүгнэлтийг чухам юунд үндэслэв

⁵⁵ МУБИС, зөвлөх профессор, доктор

гэдэг бас сонин, “дэлгүүрт байхгүй” л бол олон түмэнд хүрсэнгүй гэж дүгнэх нь маш өрөөсгөл явдал гэж бодогдоно, яагаад гэвэл “Там”-ыг 4900, “Ариутгалын орчлон”-г 6000, “Диваажин”-г 10000 хувь тус тус хэвлэсэн байдаг, дэлгүүрт байхгүй нь хүмүүсийн гар дээр очсон гэсэн үг билээ. Тухайн үеийн жишгээр бол энэ гурван номыг хэвлэсэн хувь чамлахаар тийм ч бага тоо биш, тийм учраас “Харамсалтай нь түүний орчуулга олон түмэнд хүрсэнгүй, уншигдсангүй” гэж халаглах нь наанадаж тун хөнгөмсөг дүгнэлт гэлтэй. Мөн “Утга зохиолд ойрхон, амьд сэрүүн олон хүнээс асуухад...” гэсэн өгүүлбэрийг уншаад, судалгааны арга гэхэд хэцүүхэн санагдсаны зэрэгцээ, “”асуух дээрээ хүрвэл амьд сэрүүнээс нь л асуухаас өөр яах вэ” гэх бодол төрснийг нуух юун.

Тэрээр цааш өгүүлэхдээ: “Интернэтээс эхний хоёр дэвтрийг татаж аваад унштал... Задгай цагаан шүлгээр буулгасан тэр орчуулга эзгүй цасан талд энхэл донхол дундуур түвчүүлэх мэт сэтгэгдэл төрүүллээ. Ойлгомжгүй зарим хэсгийг нь орчуулгын эхтэй тулган үзвэл ойртохгүй байна. Утга нь гарсангүй. Ур хийцийн талаар бол сайшааж хэлэх ч юм алга. Орос өгүүлбэрт тулган хадаж, дэндүү махчилснаас болж, хуучны монгол шүлгийн, тэр дундаа туульсын найраглалын өнгө аяс, тавьц алдагджээ. Товчхондоо “хүүрнэл зохиолын орчуулагч яруу найргийн өмнө боол болдог” гэсэн хатуу хэлц үг санаанд орж байлаа”[мөн тэнд] хэмээн халагласан байв. Үүнийг унших зуурт “Ашгүй дээ, жинхэнэ сайхан орчуулга гараад иржээ, тулган үзэж, хэрхэн сайжруулсныг нь залуу орчуулагч, уншигч нарт толилуулсугай” хэмээх бодол төрж, ихэд олзуурхав.

Гэтэл уншаад, анхныхтай нь тулгаад үзтэл нэг л биш ээ. Ц.Хасбаатар ч, Д.Цахилгаан ч итали эхээс нь биш, орос-зөвлөлтийн орчин үеийн орчуулгын дэг сургуулийг үндэслэгчдийн нэг хэмээн зүй ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн нэрт яруу найрагч-орчуулагч М.Л.Лозинскийн ЗСБНХУ-ын төрийн тэргүүн шагнал хүртсэн үлгэр жишээ орчуулгаас дам орчуулжээ. Гэхдээ Ц.Хасбаатарын орчуулгын өмнөтгөлд эрдэмтэн судлаач Р.Гүрбазарын тэмдэглэснээр бол анхны тэр орчуулга “...орос хэлнээс орчуулж, итали эхтэй нь тулган хянасан...” [2:8] бүтээл ажээ. Харин Д.Цахилгаан итали эхтэй нь тэгж тулгаж нягтлаагүй, “... мөн ч олон удаа, ээ чааваас, эх Итали хэлийг нь мэддэг ч болоосой хэмээн...” халагласнаар хязгаарлажээ.

Данте найраглалынхаа утга агуулгыг бүрэн илэрхийлэхэд хамгийн сайн тохирно хэмээн үзэж, терцина хэмээх гурван мөрт шүлгийн хэлбэрийг ашигласан байдаг. Шүлэглэлийн энэхүү хэлбэр бол “АВА”, “BCB”, “СДС”, “ДЕД” маягийн холбоц бөгөөд, гурван мөртийн дунд шадын төгсгөл нь дараагийн гурван мөртийн захын холбоцтой тохирч байдаг аж. Итали, орос хэл хоёулаа энэтхэг-европ язгуурын нугархай хэлний бүлэгт багтдаг тул М.Л.Лозинский эл бүтээлийг орос хэлэнд орчуулахдаа гурван мөрт шүлгийн хэлбэрийг хадгалж чадсан байна. Үүнийг дараах жишээнээс хялбархан ажиглаж болно:

ABA:

Nel mezzo del cammin di nostra *vita*
mi ritrovai per una selv(a) *oscura*,
ché la diritta vi(a) era smarrita.

Земную жизнь пройдя *до половины*,
Я очутился в сумрачном *лесу*,
Утратив правый путь во тьме *долины*.

BCB:

Ahi quant(o) a dir qual er(a) è cosa *dura*
esta selva selvagg(ia) e aspr(a) e *forte*
che nel pensier rinova la *paura*!

Каков он был, о, как *произнесу*,
Тот дикий лес, дремучий и *грозный*,
Чей давний ужас в памяти *несу*!

СДС:

ant' è amara che poco è più **morte**;
ma per trattar del ben ch' i' vi **trovai**,
dirò de l'altre cose ch' i' v'ho **scorte**.

Так горек он, что смерть едва ль **не слаще**.
Но, благо в нем обретши **навсегда**,
Скажу про все, что видел в этой **чаще**.

ДЕД:

Io non so ben ridir com' i' **v'intrai**,
tant' era pien di sonno a quel **punto**
che la verace via **abbandonai**.

Не помню сам, как я вошел **туда**,
Настолько сон меня опутал **ложью**,
Когда я сбился с верного **следа**.

Тэгвэл монгол хэл нь алтай язгуурын залгамал хэлний бүлэгт багтдаг учир нугархай хэлний хэл зүйн онцлогийг орчуулгад, ялангуяа яруу найргийн орчуулгад хадгалах ямар ч боломжгүй учраас манай хоёр орчуулагч эрхэмд тийм бололцоо байгаагүй нь мэдээж хэрэг, өөрөөр хэлбэл, монгол ардын туульсын хэлбэрээр толгой холбон шүлэглэжээ.

Одоо дээр дурдсан дөрвөн бадгийг хоёр орчуулагч хэрхэн буулгасныг харьцуулан авч үзье.

Орос эх	Ц.Хасбаатар	Д.Цахилгаан
Земную жизнь пройдя до половины, Я очутился в сумрачном лесу, Утратив правый путь во тьме долины.	Хорвоогийн насны талыг туулаад Харанхуй хөндийд замаа алдаад Бүрэнхий ойд би ирчихсэн байлаа.	Энэ насныхаа үд хэвийж байхад би Эзгүй харанхуй балар ойд зам алдаж Эргүүтэж будилж төөрлөө, яах билээ?

Энэхүү гурван мөртийн хоёр орчуулгаас үзэхэд, Ц.Хасбаатар орос эхийн агуулгыг яв цав гаргасны зэрэгцээ, “Харанхуй...”, “Бүрэнхий...” хэмээн хоёр ба гуравдугаар шадьг ижил төсөөтэй дуудлага бүхий үгээр холбож, улмаар түүний эгшиглэнт шинжийг чадамгай бүрдүүлжээ хэмээн үзэж болохоор байна. Энэ аргыг зарим судлаач “толгой давталт” хэмээн нэрлэсэн байдаг [1:350]. Түүгээр ч үл барам, “... туулаад”, “... алдаад” хэмээн эхний хоёр шадьг сүүлийг хүртэл эгшиг ижилсүүлэн холбосон нь тухайн гурван мөртийн орчуулгыг агуулга, хэлбэрийн хувьд ихээхэн чамбай болгожээ. Харин Д.Цахилгаан шадьг зөвхөн эхний авиаг ижилсүүлжээ, өөрөөр хэлбэл, “толгой холбоц” [8:87] -ын аргаар хязгаарласан төдийгүй, “сумрачный лес” буюу “бүрэнхий ой” гэх утгыг дэлгэрүүлэн “эзгүй харанхуй балар ой” болгосон нь зохиолчийн хэлэх гэсэн агуулгыг гажуудуулсан хэмээн үзэж болохоор байна. “Бүрэнхий ой”-гоор Данте тухайн үеийнхээ харанхуй нийгмийг дүрсэлсэн учраас “эзэнгүй, балар” хэмээх тодотгол илүүдсэн санагдана. Мөн “Утратив правый путь во тьме долины” буюу “Харанхуй хөндийд зам мөрөө алдав” гэсэн санааг “Эргүүтэж будилж төөрлөө, яах билээ?” хэмээн асуух өгүүлбэр болгон онцын шаардлагагүй, ярианы хэлний дэл сул хэд хэдэн үг нэмжээ. Яруу найргийн орчуулгын чанарыг дордуулдаг, ерөнхийдөө нийтлэг ажиглагддаг нэгэн үзэгдэл бол орчуулагчаас нэмсэн субъектив зүйлс юм. Ийм байдлын ихэнх шалтгаан нь голдуу шүлэгт хэмнэл үүсгэх юмуу толгой холбох гэснээс үүдэлтэй байдаг байна [4:21].

Одоо дараагийнх нь гурван мөртийг харьцуулан авч үзье:

Орос эх	Ц.Хасбаатар	Д.Цахилгаан
Каков он был, о, как произнесу, Тот дикий лес, дремучий и грозящий,	Аяа, тэр зэрлэг тайга Аюултай бэрх, аглаг зэлүүд Аймшигтай хэцүү маргахын аргагүй!	Аглаг зэлүүд ширэнгэ хөвчид тэр шөнө Айж тэвдсэн гэдэг үхэхээс наахнуур

Чей давний ужас в памяти несу!		Аргаа барж яаж явснаа мартагын аргагүй.
--------------------------------	--	---

Орос эхэд буй “... о, как произнесу” хэмээх, “бодохоос ч аймаар” гэсэн утга бүхий сэтгэлийн хөөрөл илэрхийлсэн оруулсан үг хэллэгийг хоёр орчуулагчийн аль аль нь орчуулаагүй байгаа нь гурав дахь шадад буй “мартахын аргагүй” гэсэнтэй агуулгын хувьд давхардсан хэмээн үзсэн бололтой. Ц.Хасбаатар агуулгыг орхигдуулахгүйгээр шад бүрийг дөрвөн үгээр орчуулсан бол Д.Цахилгаан тус бүрийг нь 5-6 үгээр буулгажээ. Анхны орчуулгад ийнхүү цөөн үгээр орчуулсныг “Орос өгүүлбэрт тулган хадаж, дэндүү махчилсан” гэж Д.Цахилгаан шүүмжилсэнтэй санаа нийлэхэд зовлонтой, мөн мөр бүрийг 5-6 үгээр буулгасан Д.Цахилгааныг “орос өгүүлбэрт тулган хадахаас болгоомжлоод чөлөөтэй сайхан орчуулжээ” гэж үзэхэд ч бэрх юм. Мөн Д.Цахилгаан хоёр дахь мөрөнд ойг “дикий, дремучий, грозящий” гэх гурван тэмдэг нэрээр тодотгосныг “аглаг, зэлүүд, ширэнгэ” хэмээн оноогоод “ой”-г “хөвч” болгожээ. “Монгол хэлний их тайлбар толь”-д “хөвч”-ийн үндсэн утгыг “ойр тойронд нь хүн амьдардаггүй, алслагдсан ой мод, уул ус бүхий газар” хэмээн тайлжээ. Гэтэл дээр өгүүлсэнчлэн, зохиолч “ой” гэдэг үгээр өөрийн амьдран суугаа нийгмээ ёжлон нэрлээд байгаа билээ, хүмүүс амьдран суугаа болохоор “зэлүүд” байх аргагүй мэт. Хоёр, гуравдугаар шадад “... үхэхээс наахнуур” гэсэн эхэд байхгүй үг хэллэг нэмснийг “ур хийцийг нь сайжруулжээ” хэмээн дүгнэж бас хараахан болмооргүй мэт бодогдоно.

Гурав дахь гурван мөрт орос эхдээ 7 гэсэн дугаартай ч, Д.Цахилгаан андуураад 10 гэсэн дугаартайг нь бичсэн байлаа. Өөрийнх нь биш, эх бэлтгэгчийн алдаа буй заа, гэхдээ л орчуулгаа хэвлүүлэхийн өмнө сайтар хянан магадлах хэрэгтэй байсан болов уу. Ингээд 10 гэсэн дугаартайн оронд ташааран бичигдсэн 7 дугаар бүхий зөв хувилбарыг нь энд оруулж харьцуулан үзье:

Орос эх	Ц.Хасбаатар	Д.Цахилгаан
Так горек он, что смерть едва ль не слаще. Но, благо в нем обретши навсегда, Скажу про все, что видел в этой чаще.	Тэр хөвч үхлээс өөрцгүй Тэгэвч би очсоны хувьд Тэнд үзсэнээ бүгдийг ярья	Яаж яваад төөрсөн минь яах вэ, тэр л биз Ядаж цөхөж зүдэрсэн ч үзсэн харснаа Яг үнэнээр ярих нь харин чухал байх.

Энэ хэсэгт Ц.Хасбаатар агуулгыг бүрэн дүүрэн илэрхийлсэн бол хоёр дахь орчуулгад утга санаа сүрхий гажсан мэт санагдана. Эхний шадын агуулгыг үргэлжилсэн үгээр махчлан тайлбарлаваас, “тэр ойд орсноос үхсэн бол арай дээр байх сан...” гэсэн шиг санаа байна, үүнийг Ц.Хасбаатар “Тэр хөвч үхлээс өөрцгүй” хэмээн буулгасан бол нөгөө орчуулагч нь “Яаж яваад төөрсөн минь яах вэ, тэр л биз” гэжээ. Гэтэл “... тэр л биз” гэдэг нь өгүүлэгчийн өгүүлж буй зүйлдээ хандах хандлагыг илэрхийлсэн баймж утгыг илтгэнэ, тэгэхлээр зохиолын баатар тэр ойд төөрч очсоноо нэг их тоохгүй байгаа мэт өнгө аяс цухалзаж байна.

Дараагийнх нь шадыг Ц.Хасбаатар “Тэгэвч би очсоны хувьд” хэмээн нэлээн сулхан, тэгээд бас агуулгын хувьд дулимагдуухан орчуулсан бол Д.Цахилгаан “Ядаж цөхөж зүдэрсэн ч үзсэн харснаа” гэж эхэд арай дөхүүлсэн байна. Ер нь бол “Но, благо в нем обретши навсегда” гэдэг нь “тэр ойн бүх аймшигийг даван гарч байж л үүрдийн жаргалыг олно” гэсэн санаа юм. Гутгаар шадыг Ц.Хасбаатар агуулга, хэлбэр хоёрыг аль алиныг нь баримтлан буулгасан бол Д.Цахилгаан “Яг үнэнээр ярих нь харин чухал байх” гэж мөн л эргэлзсэн таамагласан баймж утгыг өөрөөсөө нэмэн оруулжээ.

Дөрөв дэх гурван мөрт буюу орос эхэд “10” хэмээн дугаарласан бадгийн орчуулгыг авч үзвэл:

Орос эх	Ц.Хасбаатар	Д.Цахилгаан
Не помню сам, как я вошел туда, Настолько сон меня опутал ложью, Когда я сбился с верного следа.	Тавгүй нойр намайг мансууруулаад Танил замаасаа яаж төөрөөд Тайгад орчихсоноо санахгүй байна.	Тийшээ яаж очсоноо мэдэх юм алга Тэнэглэж би зүүд нойрондоо хууртав уу? Тэрслүү санаалж, зөв замаасаа гажив уу?

Энэ бадагт Ц.Хасбаатар мөн л агуулга, хэлбэрийн аль алиныг хадгалан бүрэн дүүрэн гаргахыг эрмэлзсэн нь илт, харин хоёр дахь орчуулагч агуулгыг л гаргаж байвал хэлбэрт баригдахгүй гэсэн итгэл үнэмшилдээ хэт хөтлөгджээ хэмээн бодогдлоо. Тийм ч учраас “Тэнэглэж би...”, “Тэрслүү санаалж...” гэхчлэн орос эхэд байхгүй санаануудыг нэмсний зэрэгцээ “тэнэглэж” гэдэг нь, нэгдүгээрт, яруу найрагт аль хэр тохирох үг юм бэ, хоёрдугаарт, Данте-г “тэнэглэж” гэж хэлэх нь аль хэр оновчтой вэ? гэсэн асуултууд өөрийн эрхгүй урган гарч ирж байна.

Одоо уг туульсын хоёрдугаар хэсэг буюу “Чистилище” /Ц.Хасбаатар түүнийг “Ариутгалын орчлон” гэсэн бол Д.Цахилгаан “Ариуслын орон” хэмээн орчуулжээ. С.Э./-гийн эхний бадгийн орчуулгыг шинжлэн үзье. Үүний тулд Оросын нэрт зохиолч, яруу найрагч, орчуулагч, хэл шинжлэлтэн, угсаатны зүй судлаач эрдэмтэн О.Седакова-гийн эл бадаг, түүний орос орчуулгад хийсэн ажиглалт [6:1] -аас иш татъя. Бадгийн итали эх ийм ажээ:

Per corer miglior acque alza le vele
omaì la navicella del mio ingegno
che lascia dentro a sé mar sí crudele

Үүнийг тэрээр орос хэлэнд ийнхүү үгчлэн орчуулсан байна:

Чтобы бежать по лучшим водам, поднимает паруса
уже кораблик моего гения,
который оставляет позади за собой столь жестокое море.

Түүний үгчлэн орчуулсныг монгол хэлэнд мөн үгчлэн орчуулж, эл бадаг чухам ямар агуулгатайг харъя:

Намуухан мандлаар довтолгохын тулд
миний сахиусан тэнгэрийн хөлөг догшин тэнгисийг ардаа орхиод
дарвуулаа хийсгэн хөдөллөө.

Одоо эл бадгийг монгол хэлэнд хэрхэн буулгасныг авч үзье.

Орос эх	Ц.Хасбаатар	П.Цахилгаан
Для лучших вод подъемля парус ныне, Мой гений вновь стремится свою ладью, Блуждавшую в столь яростной пучине,	Далай эрдэмт миний хань Дарвуулаа өргөж голыг чиглэн Зантай ширүүн эргүүлэгд төөрсөн Завь юугаа дахин заллаа	Оломгүй их далайн оволзсон догшин давлагааг сөрж Оосор бүчгүй мандлын хязгааргүй уудмыг туулан хөвөхүй Оройлон дэгтэрч, залуурдан яваа оюунт мэргэн багш маань:

Эндээс үзэхүл, орос эхэд байгаа “мой гений” аль алинд нь өөр өөрөөр буужээ. Уг нь “гений” гэж эртний Ромын үлгэр домогт хүн бүрийг, газар орон, эд юмсыг ивээж байдаг сахиусан тэнгэрийг хэлдэг ажээ. Тэгэхлээр “мой гений” гэж зохиолын баатар өөрийн унаж яваа усан онгоцоо нэрлэсэн бололтой. Харин Ц.Хасбаатар түүнийг “Далай эрдэмт миний хань”, Д.Цахилгаан “оюунт мэргэн

багш” хэмээжээ. Унаж яваа хүлгээ “хань” хэмээн үзэх нь монголчуудын зан заншилд байдаг л зүйрлэл хэмээн үзвэл агуулгаас нэг их гажаагүй мэт, харин тэр хань нь яагаад чухам “далай эрдэмт” болов гэдэг жаахан ойлгомжгүй. “Оюунт мэргэн багш”-ийн тухайд уянгын халил юм болов уу даа.

Эцэст тэмдэглэхэд, алдарт энэхүү туульсын хоёр орчуулгад бүрэн дүүрэн дүн шинжилгээ хийх зорилго тавьсангүй, “терцина” буюу гурван мөрт шүлгийн онцлогийг харуулсан эхний дөрөвхөн мөр, мөн хоёр дахь дэвтрийн эхний ганц бадгийг л авч үзлээ, харин залуу судлаач нар зориглон барьж авбаас магистрын зэрэг горилсон бүтээл элбэгхэн гарах, нөр их хөдөлмөр шаардсан чимхлүүр ажил болох нь мэдээж хэрэг юм. Ер нь яруу найргийн зохиол орчуулах хүнд эх зохиолын агуулга, хэлбэр, үзэл санаа, дүр дүрслэлийг нэг ерөнхий шугамд зангидаж өгөх үүрэгтэй өөр хоорондоо нарийн зохицсон айзам хэмжээ, холбоц, дотоод нугарал, хөг аяс хийгээд, үг хэллэг, зохиомжоос урган гарах ил, далд утга санааг нэг бүрчлэн буулгах нэр хүндтэй бөгөөд амаргүй зорилт тулгардаг [9:57]. Энэ үүднээс авч үзэхүл, манай хоёр орчуулагчийн аль аль нь эх зохиолын агуулгыг бүрэн дүүрэн гаргахыг эрмэлзсэн боловч, зарим газарт айзам хэмжээндээ захирагдан эхэд огт байхгүй утга санаа, үг хэллэг нэмсний зэрэгцээ “зохиомжоос урган гарах ил, далд утга санааг нэг бүрчлэн буулгах” тал дээр осолдсон эндсэн байж магадгүй тал ажиглагдсаныг зориглон өчсүү.

Дашрамд тэмдэглэхэд, сүүлийн жилүүдэд орчуулгын шүүмж ховор болоод байгаагийн нэг гол шалтгаан бол “Хүний муу үзэх гэлээ” гэж бодох болов уу? хэмээн эмээх явдал юм. Ингэж “эмээгээд” байвал орчуулгын чанар хэзээ ч сайжрахгүй бөгөөд эндүүрсэн ташаарсан орчуулга олширч, залуу хойч үеийнхний маань оюун санааны өсөлт хөгжилтөд хор хохирол учруулсаар байх болно. Эрдэмтэн зохиолч Ш.Гаадамба агсан “Нийтийн соёлын хэрэгт үнэхээр тус нэмэр больё гэж чин зориг барьсан орчуулагч хүн орчуулгын ажлынх нь алдаа дутагдлыг нууж хаалгүй хэлээд өгсөн хүнд хорсон гомдож, атгаг сэтгэлээр түүнтэй байлдахын оронд амиа хорлох гэж байхад тань үхлийн цээлийн аман дээрээс татаж авсан ачтай хүний ёсоор хүндэтгэн ачийг санаж, харин орчуулгын ажлын алдаа дутагдалтайгаа л насаараа тэмцэлдэж байгууштай” [9:57] хэмээснийг орчуулагч нар ч, орчуулгын шүүмж судлаач нар ч хаа хаанаа бодууштай билээ.

Ном зүй

1. Галбаатар Д. Уран зохиол: Онол, түүх, шүүмжлэл. Нэвтэрхий толь. (2012), УБ., , 350-р тал.
2. Данте А. Тэнгэрлэг туульс. Улсын хэвлэлийн газар. (1981), 8-р тал.
3. Данте Алигьери. Тэнгэрлэг туульс. Монсудар. (2024), 11-р тал.
4. Магсар Ц. Яруу найргийн орчуулгын уран чанарын тухайд//Орчуулга зүй сэтгүүл. (2015), №4, 21-р тал.
5. Орчуулах эрдэм. (1989), №6, УБ.
6. Седакова О. Данте. Чистилище. Песнь первая//<https://www.olgasedakova.com/Poetica/2008>
7. Цахилгаан Д. Орчуулгын тухайд//Данте Алигьери. (2024). Тэнгэрлэг туульс. Монсудар. УБ., 12-р тал.
8. Цэрэнсодном Д. Монгол шүлгийн онол түүхийн зарим асуудал. (1977), УБ., 87-р тал.
9. Шархүү А. Туурвил зүй, орчуулга судлалын зарим асуудал. (2011), УБ., 57-р тал.